

ЗӨВШӨӨРСӨН:

ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ  
ДЭМЖИХ САНЫН ГҮЙЦЭТГЭХ  
ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГОЙ  
ЗАХИРДАА СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ  
В.ҮНЭНБАТ



ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГОЙ  
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

## ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САН

“ЖИМС ЖИМСГЭНИЙ СУУЛГАЦ” ЗЭЭЛЭЭР ОЛГОХ  
ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр:

Жимс жимсгэний суулгац зээлээр олгох

Төсөл шалгаруулалтын дугаар:

СШ/18/ЖЖСЗ-01

Улаанбаатар хот  
2018 он

## A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### 1. Төслийн цар хүрээ

1.1. Тариалан эрхлэлтийг дэмжих сан (цаашид захиалагч гэх) нь чацаргана, бэсрэг алим, үхрийн нүд, чавганы суулгац зээлээр олгох төсөл шалгаруулалтыг зохион байгуулж байна.

1.2. Төсөл шалгаруулалтанд оролцогч нь иргэн, аж ахуй нэгж, байгууллага байна. Төсөлд оролцогч нь 10 000 /арван мянга/ төгрөгийн төлбөрийг аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт /ХХААГ/ тушааж, төслийн баримт бичгийг авна. Төслийн баримт бичгийн төлбөрийг аймаг, нийслэлийн ХХААГ авч нэгтгэн, 50 хувийг ТЭДС-гийн санхүүд тушаана. Төлбөр төлсөн иргэн, аж ахуй нэгж төсөл шалгаруулалтад оролцох эрхтэй.

1.3 ХХААХҮЯ, ТЭДС-гаас өмнө нь жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжих зээл, суулгацын зээл авсан иргэн, аж ахуй нэгж нь гэрээний үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаа бол төсөл шалгаруулалтад оролцуулахгүй.

### 2. Төслийн үе шат, зохион байгуулалт

2.1 Төсөлд оролцогч нь төсөл сонгон шалгаруулах энэхүү баримт бичгийн дагуу төсөл, шаардагдах баримт бичгийг боловсруулан бэлтгэж жимс жимсгэнэ тариалах талбай нь харьялагдах аймаг, нийслэлийн ХХААГ-т 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн дотор хүлээлгэж өгнө.

2.2 Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь төсөл шалгаруулалтыг энэ төслийн баримт бичигт тавигдсан шаардлагын дагуу аймагтаа явуулж 2018 оны 04 дүгээр сарын 25-ний өдрийн дотор ТЭДС-гийн ажлын хэсэгт /Өрөө №32/-т төсөл шалгаруулсан материал, шийдвэрийг ирүүлнэ.

2.3 Аймаг, нийслэлийн ХХААГ-аас шалгарсан төслийг ТЭДС-гийн ажлын хэсэг нэгтгэн хянаж, эцсийн шийдвэрийг гаргана.

2.4 Аймаг, нийслэлийн ХХААГ нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас батлагдсан, олгох суулгацын тоо хэмжээгээр суулгацын мөнгөн төлбөрийг хариуцан барагдуулах тухай гэрээ байгуулж, суулгац нийлүүлэх аж ахуйн нэгжүүдээс 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн дотор суулгацыг шалган хүлээн авч, аймагтаа татаж авна.

2.5 Аймаг, нийслэлийн ХХААГ нь төсөл шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгж, иргэнтэй суулгацын үнийг 6 жилд багтаан ТЭДС-нд буцаан төлүүлэх тухай үл хөдлөх хөрөнгө барьцаалсан гэрээ байгуулан, суулгацуудыг олгож, тариалуулах, хяналт тавих ажлыг 2018 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор гүйцэтгэнэ.

	<p>3.1 Ирүүлэх төсөл нь чацаргана, алтим, чавга, үхрийн нүдний жимст цэцэрлэгийн аж ахуй байгуулахад чиглэгдсэн байна.</p> <p>3.2 Алтим, чавганы суулгац зээлээр авах оролцогч нь өөрийн эзэмшилийн газартай, дээрх төрлийн жимс жимсгэнэ тариалсан 3-аас доошгүй жилийн туршлага, чадвартай /нотлох баримт ирүүлнэ/, төсөл хэрэгжүүлэх талбайг усалгаажуулсан, хашаажуулсан, олгосон суулгацыг цааш тариалах, арчилж ургуулах санхүүгийн бололцоотой байна.</p> <p>3.3 Чацаргана, үхрийн нүдний суулгацын төсөл шалгаруулалтад оролцогч нь өөрийн эзэмшилийн газартай, төсөл хэрэгжүүлэх талбайг усалгаажуулсан, хашаажуулсан, олгосон суулгацыг цааш тариалах, арчилж ургуулах санхүүгийн бололцоотой байна.</p> <p>3.4 Төсөлд оролцогч нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас хугацаа хэтэрсэн зээлийн өртэй иргэн, хуулийн этгээдийн жагсаалтад ороогүй байна.</p>
<b>4. Төслийн санхүүжилт</b>	<p>4.1 Суулгацын зээлийг хүүгүйгээр 6 жилийн хугацаатай , 4 дэх жилийн намраас эхлэн мөнгөөр эргэн төлөгдөх зээлдэгч, зээлдүүлэгчийн хооронд байгуулсан барьцаат зээлийн гэрээгээр зохицуулна.</p> <p>4.2 Суулгацын зээлийн 10 хувьтай тэнцэх урьдчилгаа төлбөрийг мөнгөөр тооцож төсөлд оролцогч гэрээ байгуулахдаа төлнэ.</p>
<b>5. Төсөлд оролцогчийн бүрдүүлэх бичиг баримт</b>	<p>5.1. Төсөлд оролцогч төсөл хэрэгжүүлэх чадвартайг тогтоохтой холбогдуулан дараах бичиг баримтыг төслийн хамт ирүүлнэ:</p> <p><b>5.2 Аж ахуй нэгж, байгууллага;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>а) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,</li> <li>б) Газар эзэмших эрхийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,</li> <li>в) Суулгацыг тариалах сум, дүүрэгт үйл ажиллагаа тогтмол явуулдаг, жимс жимсгэнэ тариалах чадавхитайг нотлох тухайн сум, дүүргийн ЗДТГ-ын тодорхойлолт,</li> <li>г) Төслийг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчиний чадвар, туршлагын талаарх мэдээлэл, мэргэжлийн үнэмлэх, димломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,</li> <li>д) Усалгааны эх үүсвэртэй, усалгаажуулж, хашаажуулсныг /худаг, усан сан, услагааны систем, хашаа/-г нотлох баримт/фото зураг, гэрчилгээ, өгөгдөл/,</li> <li>е) Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлгүйг нотолсон банкны тодорхойлолт,</li> <li>ё) Үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа, татварын өргүйг нотолсон харьяалах татварын албаны тодорхойлолт,</li> <li>ж) Санхүүгийн чадавхийг харуулах сүүлийн 1 жилийн буюу 2017 оны аудитаар баталгаажиж, нотариатаар гэрчлүүлсэн санхүүгийн тайлан,</li> <li>з) Суулгацын зээлд тавих хөрөнгийн баталгаа/ул хөдлөх хөрөнгийн нотариатаар гэрчлүүлсэн гэрчилгээ/ ирүүлнэ.</li> <li>и) Өмнө нь ХХААХҮЯ, ТЭДС-гаас мөнгөн болон суулгацын зээл авсан бол хэрэгжүүлсэн ажил, зээлийн эргэн төлөлтийн тайланг ирүүлнэ.</li> </ul>

### **5.3 Иргэн;**

- а) Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,
- б) Газар эзэмших эрхийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,
- в) Жимс жимсгэний тариалан эрхлэх туршлага, чадвартайг нотлох харьяа сум, дүүргийн тодорхойлолт, мэргэжлийн үнэмлэх, димломын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,
- г) Усалгааны эх үүсвэртэй, усалгаажуулж, хашаажуулсныг/худаг, усан сан, услагааны систем, хашаа/-г нотлох баримт/фото зураг, гэрчилгээ, өгөгдөл/,
- д) Иргэний орлогын татварын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар,
- е) Суулгацын зээлд тавих хөрөнгийн баталгаа /ул хөдлөх хөрөнгийн нотариатаар гэрчлүүлсэн гэрчилгээ/ ирүүлнэ.
- ё) Өмнө нь ХХААХҮЯ, ТЭДС-гаас мөнгөн болон суулгацын зээл авсан бол хэрэгжүүлсэн ажил, зээлийн эргэн төлөлтийн тайланг ирүүлнэ.

### **6. Төслийн бичиг баримтын агуулга**

6.1. Төслийн бичиг баримт нь дор дурдсан бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:

- а) Төслийн танилцуулга/төслийн нэр, байршил, хаяг, утас, төслийн үндэслэл, зорилго, зорилт, төслийн хүрээнд хийгдэх ажил/
- б) Жимс, жимсгэний тариалалт, ургуулалтын технологи /таримлын төрлөөр/
- в) Төсөл хэрэгжих хугацаа, үе шат
- г) Зах зээлийн судалгаа, маркетингийн төлөвлөгөө
- д) Гарч болох эрсдэл, тэдгээрийг даван туулах/өвчин, хортон, технологи, борлуулалт г.м/ төлөвлөгөө
- е) Төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн,
- ё) Зардлын тооцоо,
- ж) Зээлийг эргэн төлөх хугацааны график

### **7. Төслийн бичиг баримтыг тодруулах**

7.1 Төсөлд оролцогч нь төслийн бичиг баримтын талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр, эсхүл утсан холбоо ("Утсан холбоо"-нд зөвхөн факсыг хамруулна)-гоор төслийн урилгад заасан захиалагчийн хаягаар мэдэгдэнэ.

### **8. Төсөл шалгаруулалта нд оролцох зардал**

8.1 Төсөлд оролцогч төслөө бэлтгэх, ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд эдгээр зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.

### **9. Эрх бүхий төсөлд оролцогч**

9.1 Төсөлд оролцогч нь Монгол улсын иргэн, хуулийн этгээд байна.

9.2 Дараах тохиолдолд төсөлд оролцогчийг эрх бүхий бус гэж үзнэ. Үүнд:

- 9.2.1 Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөлд байгаа;

- 9.2.2 Төсөлд оролцогч нь төслийн баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой;
- 9.2.3 Илт худал мэдээлэл бүхий төсөл ирүүлсэн;
- 9.2.4 Энэхүү төсөл шалгаруулалтад хоёр буюу түүнээс дээш тооны төсөл ирүүлэгчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 9.3 Төсөлд оролцогч 9.2.1 - 9.2.4-д дурдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй.

---

## Б. ТӨСӨЛД БЭЛТГЭХ

---

10. Төслийн иж бүрдэл 10.1. Төсөлд оролцгчийн ирүүлэх төсөл нь дараах зүйлээс бүрдэнэ:
- 10.1.1 Төсөлд оролцохыг хүссэн хуулийн этгээдийн албан бичиг, иргэний хүсэлт
- 10.1.2 Боловсруулсан төслийн баримт бичиг
- 10.1.3 Төсөлд оролцгчийн төсөл хэрэгжүүлэх чадвартайг нотлох 5.2, 5.3, 9.3 -т шаардсан баримт бичиг

---

## В. ТӨСӨЛ НЭЭХ, ҮНЭЛЭХ

---

11. Төслийг хүлээн авах 11.1. Төсөл шалгаруулалтын урилгад заасан газар, цаг хугацаанд аймаг, нийслэлийн ХХААГ-т төслийг хүлээн авна.
12. Төслийн тодруулга 12.1. Төслийг хянан үзэх, үнэлэх болон харьцуулахад зайлшгүй шаардлагатай тохиолдолд төсөлд оролцгоос түүний ирүүлсэн төслийн талаар тодруулга ирүүлэхийг хүсч болно.